

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Байршил: Тухайн оффисын байр нь Улаанбаатар хотын А зэрэглэлийн бүсэд байршилтай байна;
2. Оффисын барилга нь оффис үйлчилгээний зориулалттай, компанийн бизнесийн нэр хүндэд нийцэхүйц орчин үеийн оффис шийдэл бүхий байх, үзэгдэх орчин сайтай, техникийн шаардлага хангасан байх;
3. Түрээслүүлэх албан тасалгааны зориулалттай нийт талбайн хэмжээ нь 120 м.кв-аас багагүй байна;
4. Оффисын барилгын дулаан зогсоолоор компанийн 2 автомашиныг оффис түрээсийн хугацаанд 24 цагийн турш тасралтгүй хангах;
5. Оффисын барилгын гадна авто зогсоолд компанийн 3 автомашиныг зогсоолоор хангах;
6. Ойр орчмын гадна талбайд авто зогсоолын хүрэлцээ хангалттай байх;
7. Давхарт эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй, халуун хүйтэн устай, техникийн шаардлага хангасан байх;
8. Түрээсийн барилга нь орчин үеийн цахилгаан шатаар тоноглогдсон техникийн шаардлага хангасан байх ;
9. 7 хоногт 1 удаа тогтмол оффисын цэвэрлэгээ, ариутгал хийх үйлчилгээтэй байх;
10. Түрээслүүлэгч нь түрээсийн байр нь, 24/7 цагийн харуул хамгаалалттай байх;
11. Кабелийн телевиз, интернэтийн сүлжээ, телефон утасны сүлжээ орсон байх;
12. Өрөө, заал нь дулаан болон агаар сэлгэх системийг холбогдох стандартын дагуу шийдвэрлэсэн байх, шаардлагатай өрөө, заал нь дулаан, агааржуулах тоног төхөөрөмжөөр тоноглогсон байх;
13. Гэрэлтүүлэг /цонх, цахилгаан/, дулаан болон ус хангамжийн шугам сүлжээг стандартын дагуу шийдсэн байх;
14. Албан ёсны зөвшөөрөлтэй компаниар барилгад гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байх;

Үнийн санал ирүүлэх

1. Оффисын байрны түрээсийн үйлчилгээг 1 жилийн хугацаанд үзүүлэхээр тооцож, тендерийн үнийг ирүүлэх , үнийн задаргаа, тооцоо, нэгж үнийг тендерийн хамт ирүүлнэ.
/м.кв* нэгж үнэ* 12 сар= тендерийн үнэ/
2. Нэгж үнэ гэдэг нь нэг м.кв талбайд нэг сард ноогдох үнийг хэлнэ. Энэ үнэд НӨАТ, хэрэглээний ус, цахилгаан, дулаан, цахилгаан шат, хог хаягдал, автомашины дулаан зогсоолын түрээсийн үнийг багтааж тооцож ирүүлсэн байна.